

2022 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар төвд хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгчийн код олгох, хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, дугаарын баталгаажуулалт хийж, эзэмшигчийн болон түрээсийн хөдлөх бүрэлдэхүүнийг мэдээллийн санд бүртгэж өгөхийг хүссэн 99 хүсэлт ирсний дагуу хүсэлтүүдийг 100% шийдвэрлэсэн болно. 1542 хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгож, 710 хөдлөх бүрэлдэхүүний дугаарын баталгаажуулалт хийж, 1244 түрээсийн хөдлөх бүрэлдэхүүн нийт 3496 хөдлөх бүрэлдэхүүнийг /худалдаж авсан болон түрээсийн чингэлгийн тоог нэмээгүй болно/. Мөн 1 хуулийн этгээдийн 3 хагас вагон актлагдсаны дагуу мэдээллийн сангаас хасалт хийн бүртгэсэн.

Үүнд:

1. Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгчийн код олгох:

- Эзэмшигчийн код – 13
- Түрээслэгчийн код – 13

2. Хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох:

- Зүтгүүр – 24 /гол зам ба сэлгээний/
- Машин механизм – 10
- Хагас вагон – 630
- Битүү вагон – 8
- Өөрчлөн тоногдсон – 110
- Хоппер – 57
- Тавцант вагон – 703
- Худалдаж авсан чингэлэг – 398

3. Хөдлөх бүрэлдэхүүний дугаарын баталгаажуулалт хийх:

- Тавцант вагон – 700
- Хагас вагон – 10

4. Түрээсийн хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх:

- Хагас вагон – 158
- Тавцант вагон – 967
- Цистерн вагон – 100
- Битүү вагон – 19
- Түрээсийн чингэлэг - 2560

2022 онд худалдаж авсан 1 хуулийн этгээдийн 398 чингэлэг, түрээсийн 1 хуулийн этгээдийн 2560 чингэлэг бүртгэгдсэн.